

1921 ОНЫ ХУВЬСГАЛААР ТӨРСӨН “ШАР ТУГ” ДУУНЫ ТУХАЙ

С.Отгонжаргал

Монгол улсын их сургууль, Нийгмийн шинжлэх ухааны сургууль. Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга: 1921 онд Ардын журамт цэрэг “Улаан туг” дууг дуулж байсан эсэхийг тодруулахын зэрэгцээ уг хувьсгалын хөдөлгөгч хүч нь гагц ядуу ард бус лам, хар, дээдэс, доодос бүгдээрээ нэгдэн **Нэгдсэн фронт** болж хувьсгалд орсон юм гэдэг санааг хувьсгалаар төрсөн “Шар туг” дуугаар илэрхийлэхийг зорьсон болно.

Түлхүүр үг: Улаан туг, шар туг, жанжин туг, ногоон туг, “Нэгдсэн фронт”, Үндсэн хууль.

Английн Кэмбрижийн Их сургуулийн Монгол судлалын төвийн урилгаар 2002 оны 10-р сард англи, америк, дани эрдэмтдэд “XX зууны Монголын түүхийг шинээр эргэн харахуй” сэдвээр цуврал лекц уншиж билээ. Тэр үед Кэмбрижийн Их сургуулийн Нийгмийн хүн судлалын тэнхимийн эрхлэгч, Британийн академийн гишүүн, профессор Каролин Хамфри, Монгол судлалын төвийн захирал эрдэмтэн Дэвид Снитз, Монгол судлалын төвийн дэд захирал, эрдэмтэн Хүрэлбаатар нар, монголын нэрт эрдэмтэн академич Ш. Бира гуайтай уулзах уулзалт болоход өчүүхэн судлаач надад оролцох аз тохиосон юм. Уг уулзалтын үеэр Ш.Бира гуай миний уншиж буй лекцийн талаар сонирхоход нь би 1921 оны болон 1990 оны хувьсгалууд залгамж холбоотой болох тухай болон “1921 оны хувьсгалын хөдөлгөгч хүч нь үндэсний нэгдсэн фронтыг бүрдүүлэгч хар, шар феодалууд, өмчтөн ардууд байсан, 1921 оны хувьсгал нь үндэсний ардчилсан буюу хөрөнгөлөг шинж чанартай хувьсгал” хэмээн үзэж байгаагаа хэлсэнд Бира гуай миний дэвшүүлж буй саналыг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа гадны эрдэмтдийн дунд шууд хэлж билээ. Тэгэхэд би судалгааныхаа явцад гаргасан гол гол үндэслэлүүдээ ойлгуулахыг хичээн тайлбарлаж байсан нь саяхан мэт санагдана. 2008 онд “Аав хүү Рерих нар ба Монгол” нэртэй ном Улаанбаатар хотноо хэвлэгдэн гарч түүнд Ш.Бира гуай “Ю.Н.Рерих багшийн тухай дурсамж” нэртэйгээр дурсамжаа бичсэн байв. Энэ дурсамжиндаа Ш. Бира 1921 оны хувьсгалаар дуулагдаж байсан дууны талаар сонирхолтой мэдээллийг өгсөний зэрэгцээ энэ хувьсгалын талаархи дүгнэлтээ оруулсан нь миний анхаарлыг ихээхэн татсан юм. Тэрээр 1921 оны хувьсгалчдын дуулж байсан дууны тухай дурсахдаа “Энэ дуу тэр үед Монголд маш өргөн дэлгэрсэн байсан бөгөөд хүн бүр, хөгшин залуугүй дуулдаг байжээ. Миний үеийнхэн хүүхэд ахуй цагаасаа энэ дууг “Улаан туг”-ийн аяар дуулдаг байсан билээ. Миний найз Өвөр монголоос ирсэн одоо 75 настай Содномдаржаа энэ дуу Өвөр монголд бас их өргөн дэлгэрсэн тухай надад ярих” гээд аман зохиол судлагч, 85 настай профессор П.Хорлоогийн тусламжтайгаар “Жан Шамбалын дайн” дууны зарим хэсгийг сэргээн оллоо. Энэ дуу 1921 оны ардын хувьсгалын үед гарчээ. Энэ дууг анх түрүүнд хувьсгалт цэргийн туганд зориулан гаргажээ. Жанжин туг, улаан туг, шар туг, ногоон туг гэсэн дөрвөнтугтай байжээ. Бид энэ дууны дараагийн бадгуудыг П.Хорлоо гуайгаас олов. Үүнд:

1. Жанжин тугийг мандуулаад
Зэвхий гаминг дарцгаая
Жан Шамбалын оронд
Заавал ч үгүй төрцгөөе
2. Шар тугийг мандуулаад
Шажны сүрийг бадруулая
Шивь нар болсон бид нар
Шамбалын дайнд мордоцгооё
3. Ногоон тугийг мандуулаад
Нсёдын сүрийг бадруулая
Нокид болсон гаминг
Номхон бороор даруулая” (1.137-138) гэжээ.

Энэ дууны үг нь 1921 онд хувьсгалчдын дуулж байсан дууны эх гэдэг нь эдүгээ бидэнд тодорхой болоод байна. Энэ дууны үг утга үндсээрээ өөрчлөгдөж, зөвхөн аяы нь ашигласнаар одоогийн “Улаан туг” дуу зохиогджээ. Нийслэл хүрээг чөлөөлөхөдөө хувьсгалчдын дуулж орж ирсэн “Шар туг”-ийн дууг “Улаан туг”-ийн дуу болгох ямар шаардлага байсныг дор бид товч тайлбарлах болно. Академич Ш.Бира цааш нь бичихдээ “Монголын хувьсгалчдын янз бүрийн туганд зориулан гаргасан энэ дууны агуулгаас үзэхэд Монголын ардын хувьсгал эхэн үедээ үнэхээр нийт ард түмний буюу нийт үндэстний шинж чанартай байсан нь тодорхой байна. Үндэсний хувьсгалд ноёд, лам нар, ардууд гэх мэт хүн амын бүх давхаргын төлөөлөгчид оролцсон байна. Бидний дээр өгүүлсэн олон өнгийн тугнууд нь монголын хувьсгалчдын анхны бүрэлдэхүүн янз бүр байсан бөгөөд юуны түрүүнд үндэсний тусгаар тогтнолоо олохын төлөө тэмцэж байсныг харуулж байна. Энэ бүхнээс үзэхэд **ардын хувьсгал гэдэг нь зөвхөн ядуу ардын гэдэг утгаар бус ард түмний гэдэг утгатай байсан** бөгөөд зөвхөн хожуу үед тэр хувьсгалын утга агуулгыг зөвхөн ядуу ардын болгон **хүчээр гуйвуулан өөрчилсөн** хэмээн үзүүштэй” (1.138) гэжээ. Ш.Бира гуайн 1921 оны хувьсгалын гол хөдөлгөгч хүч, хувьсгалын талаар ийнхүү дүгнэсэн нь Кэмбрижид лекц уншиж байсан үеийн маань дүгнэлттэй тохирч байгаа юм. Эрдэмтэн хүн түүхийг мета чанарт нь суурилуулж, плюрализмын зарчимд тулгуурлан дүгнэх чадвартай байдгийг харуулж буйн нэг жишээ хэмээн талархан хүлээж авсанаа нуух юун. Уг дууг Ш.Бира Сүхбаатарын цэргүүдийн зохиосон дуу хэмээн бичсэн бол урлаг судлаач Ж.Саруулбуян “Н.Рерихийн туурвилын зөн совингийн нууцлаг шидийн тухайд” илтгэлдээ “Рерихийг Монгол нутагт орж ирэхэд монголчууд Шамбалын орны тухай дууг газар сайгүй дуулж байжээ. Энэ Шамбалын дууг хэн зохиосон бэ гэхэд тэд Сүхбаатар гэж хариулжээ. Энэ нь өнөөдрийн бидний бараг мартагнахаа дөхөж байгаа ардын хувьсгалын хүчит уриа дуудагын илэрхийлэл болж байсан “Улаан туг” дуу байжээ.

Улаан тугийг мандуулаад

Улсын сүрийг бадруулаад

Урвасан хулгай дайснуудыг

Уухай хийгээд дарцгаая

Шар тугийг мандуулаад

Шашны сүрийн бадруулаад

Шавь нар болсон биднүүд

Шамбалын дайнд мордовоо хөө

гэх мэтээр улаан, хөх, ногоон, шар тугаа мандуулсан олон бадгууд байсан нь хувьсгалын үзэл суртлаас болж орхигдон мартагдсан ажээ” (2.1) гэснийг талархан үзүүштэй байгаа юм. Учир нь эдүүгээ энэ дуу ямар учраас, яагаад жинхэнэ эхээрээ дуулагдалгүй өөрчлөгдөх болов оо гэсэн асуултыг санал нэгтгэйгээр тавих боломж бидэнд олдож байгаа юм. Гурван туг ч бай дөрвөн туг ч бай ямар ч л гэсэн энэ дуу “Улаан туг” гэсэн нэртэй дуу байгаагүйг ганц бичигч биш олон судлаачид дэвшүүлэн тавьж байгаагараа цаашид судлаачдын анхаарлыг татаж үнэн мөн нь тодрох эхлэл хэмээн ойлгож байна. Өгүүллийг бичигч ийнхүү олзуурхахын зэрэгцээ энэ дууг жанжин Сүхбаатар зохиосон гэсэн ташаа ойлголт өгөхөөс болгоомжилж байгаа юм. Дээр өгүүлсэнчлэн энэ дууны үгийг жанжин Сүхбаатарын цэргүүд, Сүхбаатар өөрөө зохиосон гэсэн санаа илэрхийлэгдсэнийг нягтлах нь зүй болов уу. Америкийн монголч эрдэмтэн Кристофер Этвуд “1921 онд Буяннэмэх зохиосон” (3.486) гэсэн байхад “XX зууны Монголын түүхийг шинээр эргэн харахуй” номондоо бичигч “Энэ дууг Магсар хурцын Дугаржав 1921 онд зохиожээ.” (4.25) гэсэн байна. Мөн академич Ш.Бира уг дууг “Жан Шамбалын дайн” гэдэг дуу байжээ хэмээн өөрийн саналаа бичилгүй профессор П.Хорлоогоос тэмдэглэж авсанаа мэдээлэл маягаар бидэнд өгснийг нягтлуштай байгаа юм. Рерихийг бид хувь хүнийх нь хувьд түүхэн өнцгөөс харж тайлбар хийх хэрэгтэй санагдана. Бичигч энэ тухай өөрийн санаа бодлоо дараа тодорхой бичих болно.

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

Өгүүлэл бичигч лекцээ 2002 онд уншиж байхдаа энэ дууны талаар асуудал дэвшүүлж байсан хийгээд 2003 онд уг лекцээ монгол, англи хэлээр хэвлүүлж олон түмэнд хүргэсэн юм. Уг номонд “1921 оны 3-р сарын 18-нд Хиагтыг чөлөөлж анхны ялалтаа хийсэн Ардын журамт цэрэг Улаан армийн анги нэгтгэлийн хамт 7-р сарын 6-7-нд Нийслэл хүрээнд орж иржээ. Ингэж орж ирэхдээ журамт цэргүүд нэгэн хувьсгалт дуу дуулж орж ирсэн нь бидэнд “Улаан туг” гэдэг нэртэйгээр хүрч одоог хүртэл дуулагдсаар байгаа билээ. 1921 онд дуулж байсан дууны үг Ж.Бадраа агсанд хадгалагдаж байгаад Төрийн соёрхолт хөгжмийн зохиолч Н.Жанцанноровт очсон тухай дам сураг байдаг. Харин энэ удаад Кристофер Этвүдийн номноос мөн МУИС-ийн Монгол Хэл Соёлын Сургуулийн багш доктор Г.Гантогтохоос тэмдэглэж авсан дууны үгний хувилбаруудыг сонирхуулья.

Улаан тугийг мандуулаад

Улсын сүрийг бадруулаад

Урвасан хулгай Найдан ванг

Уухай хийгээд дарваа хөө

Шар тугийг хийсгээд

Шашны сүрийг бадруулаад

Шавь нар болсон бид

Шамбалын дайнд мордов оо хөө

Шар хамбан тугаа залаад мордоё

Жан шамбалд зоволтгүй төрье

Шашин төрөө хослон мандуулж

Шар хар цэнгэн жаргацгаая” (доктор Г.Гантогтохоос тэмдэглэж авсан үг)
гэсэн байхад Кристофер Этвүдийн номонд

Улаан тугийг мандуулаад

Улсын сүрийг бадруулаад

Урвасан хулгай дайснуудыг

Уухай хийгээд дарцгаая

Шар тугийг мандуулаад

Шашны сүрийг бадруулаад

Хар шар бүгдээр

Харгис дайсныг дарцгаая (3.486)

Дууны энэ үгнүүд 1921 оных хараахан биш 1924 оноос хойшхи байж болох талтай юм. Улсын Анхдугаар их хурлаар хаант ёсыг халж Бүгд Найрамдах засгийг тогтоож, анхны Үндсэн хууль батлахдаа улсын туг далбааг Шар байсныг Улаан тугаар сольж хуульчлан баталснаар дууны нэр ч “Улаан туг” болсон гэхэд үгүйсгэх аргагүй юм. Энэ дууг Магсар хурцын Дугаржав 1921 онд зохиожээ. Товхимол тэрлэгч дууны үгийг яагаад олзуурхаад байгааг уншигч авхай та бараг гадарлаж байгаа бизээ. Тухайн үед журамт цэргийн дуулж байсан дууны үгийг тодруулах нь **Нэгдсэн фронтын** асуудлаас гадна **1921 оны хувьсгалын шинж чанарыг** ч тодруулахад чухал ач холбогдолтой гэж үзсэнийх. Шар хар цөмөөр дарлах дарлагдахын зовлонгүй аж төрж, шашин төрийг үнэн сэтгэлээс сүсэглэн мандуулах **намын зорилт** энэ дуунд илэрхийлэгдэж байгаа нь олзуурхууштай санагдана. Энэ удаад дээрх дууны талаар түр орхиод бидний дунд дуулагдаж ирсэн “Улаан туг” дууны үгийг харьцуулж үзэхэд сонин байх болов уу хэмээн оруулав.

Улаан тугийг мандуулаад

Улсын сүрийг бадруулаад

Уравсан хулгай дайснуудыг

Уухай хийгээд дарцгаая

Сүртэй тугийг мандуулаад

Сүрлэг жагсаалаар явцгаая

Сүүлийн үеийн дайснуудыг

Сөнөөн устгаж дарцгаая” (4.24-26) гэж бичжээ.

“Улаан туг”-ийн дууг өнөөдөр бид яагаад нягталж, жинхэн эхий нь хайх болов оо гэдэгт хариу өгөхөөсөө өмнө Ардын засгийн анхны Ерөнхий сайдынхаа зургийг хэрхэн тодруулсан талаар дурьдахад л хангалттай болов уу гэж бодлоо. “ Ардын засгийн анхны Ерөнхий сайд **Д.Чагдаржав**. /1880-1922/ Энэ хүний түүх 1990-ээд онд түүний зургийг олж намтрыг нь тодруулах хүртэл ихээхэн балархай байсан юм. Эрдэмтэн О.Пүрэв Д.Чагдаржавыг таньдаг гэсэн айлуудаар орж намтрыг нь тодруулж явахдаа Д.Чагдаржав байж магадгүй гэсэн нэгэн зургийг олжээ. Тэрээр хэд хэдэн түүхчидтэй ярилцаж нягталсны дараа төвийн сонинд зургийг хэвлүүлэхэд сонины зөвлөл рүү нэгэн эмээ утасдсан байна. Энэ дагуу очиж уулзахад 90 гарсан эмээ сонины зургийг миний авга хэмээн бурханыхаа хажууд залж, зул өргөсөн байжээ. Ингэж Ардын засгийн анхны Ерөнхий сайд Д.Чагдаржавын зураг мөн гэдэг нь батлагджээ.” (4.55) 1921 оны хувьсгалаар тогтсон Ардын засгийн анхны Ерөнхий сайдынхаа зургийг эрэн сурвалжлах хэмжээнд хүртлээ түүхээ гуйвуулсан бидэнд дууны үг гуйвагдах нь энгийн зүйл мэт санагдах бизээ.

1921 онд Монголын ард түмэн социалист бус үндэсний ардчилсан шинж чанар бүхий хувьсгалыг хийж монгол улсаа хүн төрөлөхтний жам ёсны зам болох зах зээлийн эдийн засгийг баримжаалан хөгжүүлэх бодлогыг барих болжээ. Гэвч тусламж авсан Орос улсад жинхэнэ ёсны социалист хувьсгал ялсан байсантай холбоотой Монгол улс Орос улсын хооронд гүнзгий зөрчил үүссэн байдаг. Ийм ч учраас хувьсгалын гол лидерүүд зохиомол хэрэгт тулгагдан егүүтгэгдсэн юм. 1924 оны Үндсэн хууль батлагдсан үнэн түүхээс монголын хувьсгалчдын баримталж байсан үзэл бодол тодорхой харагддаг. Монгол, Орос улсын хөшигний ар дахь ширүүн тэмцэлд монголчууд ялагдсанаар 1921 оны хувьсгалыг социалист маягийн хувьсгал хэмээн түүхийн ном зохиолуудаар дамжуулан сурталчлах болсон түүхтэй. 1924 онд батлагдсан Монгол улсын үндсэн хууль нь угтаа Орос улсын үндсэн хуулийн орчуулага байсан хийгээд энэ Үндсэн хууль батлагдсанаар төрийн шар хамбан туг улаан туг болж, Монгол улсын нийслэл “Улаанбаатар” нэртэй болсон байна. Үндсэн хуулийн “Улсын тамга ба сүлд тэмдэг туг далбааны тухай” зургаадугаар бүлэгийн 49 дүгээр зүйлд: “Улсын туг далбааг улаан өнгөтэй бөгөөд дунд нь улсын сүлд тэмдэгийг оруулан үйлдүүлж гүйцэтгүүлбээс зохимой.” 50 дугаар зүйлд: “Тус улсын их бага хурлыг Улаанбаатар хотод хуралдуулан байваас зохимой” (5.40) гэжээ. Монголд ингэж улаан өнгө ноёрхох болсноор “ Шар туг”-ийн дуу “Улаан туг” ийн дуу болжээ гэмээр санагдана. Энэ дууны үгийг бүрэн засварлах болсон шалтгаан нь гэвэл 1921 оны хувьсгалд Богд хаан болон хар шар феодалууд оролцоогүй харин үгээгүй ядуус тэдний эсрэг тэмцэж социалист хувьсгалыг хийсэн юм гэсэн марксист онолд таацуулах гэсэн Орос улсын бодлоготой холбоотой байв. “Шар туг”-ийн дуунд хувьсгалд оролцсон бүхий л хүчнийг тодорхой дурдсан болохоор солих шаардлага гарсан гэлтэй.

Жанжин тугийг мандуулаад

Зэвхий гаминг дарцгаая

Жан Шамбалын оронд

Заавал ч үгүй төрцгөөе гэсэн бадагт журамт цэрэг буюу эх орноо харийн түрэмгийлэгчдээс чөлөөлөхөөр сэтгэл зориг шулуудсан хэсгийг тодруулж байхад

Шар тугийг мандуулаад

Шажны сүрийг бадруулая

Шавь нар болсон бид нар

Шамбалын дайнд мордоцгооё гэсэн дууны бадагт Богд хаан болон шар феодалуудаас эхлээд шавь нар болсон ардууд оролцсоныг илэрхийлжээ.

Ногоон тугийг мандуулаад

Ноёдын сүрийг бадруулая

Ножид болсон гаминг

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

Номхон бороор даруулая” гэсэн бадагт бидний хэлж заншсан хар феодалууд оролцсоныг илэрхийлэхийн дээр ард түмний дунд “номхон бор” хэмээн алдаршсан улаан цэргүүд оролцсоныг бас илэрхийлсэн байна. 1921 оны хувьсгалд өмчтөн монголчууд дээдэс доодосгүй оролцохдоо хотон дахь малаа буюу өмчөө нийгэмчилье гэж ороогүйг “Шар туг” дуугаар илэрхийлж байна гэж үзмээр байгаа юм.

Abstract

In this article the author tried to clear out if in 1921 the song “Red banner” was the song of the revolutionary army. Also, the author aimed to expose through the song called “Yellow banner”, which was born during the revolution, that the moving force of the revolution was not only the poor people but also the noblemen, lamas, ordinary herders and the poor joined together in the united front.

Ном зүй

1. Аав хүү Рерих нар ба Монгол. УБ.2008.х.137-138
2. Ж.Саруулбуян “Н.Рерихийн туурвилын зөн совингийн нууцлаг шидийн тухайд” илтгэл (хэвлэгдэж буй)
3. Christopher P.Atwood. Young Mongols and Vigilantes in Inner Mongolia's Interregnum Decades, 1911-1931. Volume one Netherlands. 2002.
4. С.Отгонжаргал.ХХ зууны Монголын түүхийг шинээр эргэн харахуй. (1921-1990).УБ.2003.
5. БНМАУ-ын Үндсэн Хууль.УБ. Монгол улсын 14 дүгээр он.